

“Фронтер Лэнд Групп” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит хурлын тэмдэглэл

2020.04.02

Улаанбаатар хот

“Фронтер Лэнд Групп” ХК-ийн ТУЗ-ийн ээлжит хурал 2020 оны 04 сарын 02 -ны өдөр 15 цагт Сүхбаатар дүүрэг, Бага Тойрог, Пума Имтериал зочид буудлын 2-р давхарт байлах хурлын бага танхимд эхлэв.

Хуралд ирсэн ТУЗ-ын гишүүдийг холбогдох журмын дагуу бүртгэн авав.

Хурлын дарга Г.Оюунболд хурлыг нээж, хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах.
3. Компанийн өөрчлөн байгуулах, хэлбэр өөрчлөх эсэх тухай, компанийн цаашдын үйл ажиллагааг хэрхэх эсэх тухай
4. Өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх, шаардах эрх хэрэгжүүлэх тухай хэлэлцэх
5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилсэн найруулгыг батлах
6. Ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсэн тухай ТУЗ-ын шийдвэрийг танилцуулах
7. Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл батлах
8. Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээг хэлэлцэх, сунгах
9. Бусад

Хурлын дарга Г.Оюунболд

3 сарын 23 ны ээлжит бус хурал зарласан боловч хурал ирц хүрээгүйн улмаас хойшилсон ба 4 сарын 2-нд 71 хувийн ирцтэй хүчин төгөлдөр хуралдаж байна. Хэлэлцэх асуудалыг Компанийн захирал О.Амартүвшин танилцуулна.

Компанийн захирал О.Амартүвшин:

За би дээр дурдсан хэлэлцэх асуудлыг эхнээс нь дэлгэрэнгүй танилцуулаад явъя. Нэгдүгээр асуудал: 2019 оны хувьд эдийн засгийн байдал хүндхэн байлаа. Үүн дотор үл хөдлөх хөрөнгийн зах зээл нилээд уналттай байна. Компанийн хувьд үл хөдлөх хөрөнгүүдээ аль болох түрээслэгчидтэй байлгах мөн хуучин харилцагчдаа авч үлдэх тал дээр бүхий л шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.

Үүний дүнд 2019 оны үйл ажиллагааны алдагдал өнгөрсөн жилүүдээс буурсан үзүүлэлттэй байна. Компани урд жилүүдэд нилээн хэмжээны өртэй байсан ба 2019 онд ихэнх өр төлбөрөө барагдуулж үйл ажиллагааны зардлаа хэмнэж чадлаа. 2020 онд

ашигтай ажиллаж чадахаар нөхцөл байдал бүрдэж эхэлсэн хэдий ч Ковид 19- холбоотой түрээсийн үйл ажиллагаа доголдож эхэллээ. Та бүхний өмнө 2019 оны санхүүгийн аудитлагдсан тайлан байна. Санхүүгийн тайлангийн талаар асуух зүйл байна уу?

Хурлын дарга Г.Оюунболд

Энэ нь 2019 оны тайлан бөгөөд хэрэв асуух зүйл байхгүй бол 2020 оны төлөвлөгөөг батлах тухай ярилцах уу?

Хувьцаа эзэмшигч Ж. Энхтунгалаг:

Би Ди Сек компанийн хувьцааг хэзээ худалдаж авсан юм бэ?

Компанийн захирал О.Амартүвшин:

Би Ди Сек –ын хувьцааг Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Бус хурлаар худалдаж авах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргаж надад энэ үүргийг өгсөн. Би Ди Сек – ын хувьд хувьцаа худалдан авах гэрээг 2 сарын 4 өдөр хийсэн бөгөөд 3 сард дуусгах эс бөгөөс алданги тооцогдох нөхцөлтэй байсан. Бидний зүгээс компанийн өр төлбөрийг барагдуулж дууссаны дараа биржээр дамжуулан өнгөрсөн долоо хоногт худалдан авалт хийж дууссан. Мөн хуралд оролцоогүй болон жижиг хувьцаа эзэмшигчид саналаа тавих эрхтэй байгаа.

Хурлын дарга Г.Оюунболд

Тийм. Би Ди Сек компани өөрийн эрхийн дагуу хүсэлтээ тавьж бид хүсэлтийн дагуу хувьцааг худалдаж авсан. Мөн өнөөдөр хурлаар хэрэв хувьцаа эзэмшигч хувьцаагаа буцаан зарах санал тавих юм бол энэ эрх нь бүрэн нээлттэй байгаа. Энэ нь компани зөвхөн Би Ди Сек – компанийн хувьцааг худалдаж авсан гэсэн үг биш юм. Бусад хувьцаа эзэмшигчдэд ч гэсэн нээлттэй байсан. Саналын хуудас бөглөхөөс өмнө энэ шаардах эрхээ тавьж болно.

Хувьцаа эзэмшигч Ж. Энхтунгалаг:

Би Ди Сек компанийн хувьцааг худалдаж аваад одоогын компанийн санхүүгийн байдал ямар байна?

Компанийн захирал О.Амартүвшин:

Би Ди Сек- ын хувьцааг компани өөрийн борлуулсан үл хөдлөх хөрөнгийн мөнгөөр эргүүлэн авсан ба өнөөг хүртэл хуримтлагдаад байсан газрын татвар, үл хөдлөхийн татвар болон банк, банк бус санхүүгийн байгууллагын бүр өр төлбөрийг барагдуулж дууссан. Компанийн үйл ажиллагаа одоогоор хэвийн үргэлжилж байна. Өөр асуулт байна уу, хэрэв байхгүй бол дараагийн асуудал буюу 2020 оны үйл ажиллагааны чиглэл гэсэн сэдэв рүү орох уу?

Хуралд оролцогчид:

Байхгүй. Бүгд дэмжиж байна.

Компанийн захирал О.Амартүвшин:

Хувьцаа эзэмшигчдын тавьсан саналын дагуу өөрсдийн үйл ажиллагааг өөрчлөн, сургалт зохион байгуулах, интернэт бизнес хийх, мэдээлэл технологийн чиглэл рүү орохоор бэлдэж байна. Харамсалтай нь энэ Ковид 19 өвчнөөс шалтгаалан танхимын сургалтын үйл ажиллагаа хойшлогдож мөн эрсдэлтэй харагдаж байна. Тиймээс энийг онлайн худалдаа, онлайн сургалт болгох талаар бэлдэж байна.

Хувьцаа худалдан авах үйл ажиллагаа явагдсан учир бид шинэ үйл ажиллагааны чиглэлүүд дээр хөрөнгө оруулж чадсангүй. Энэ үйл ажиллагааг эхлэхэд ойролцоогоор 150 сая төгрөг орчим хэрэгтэй байна. Мөн бид энэ үйл ажиллагааны чиглэлээ өргөжүүлэн өөр Монголтой ижил төстэй мэдээллийн технологийн шийдлийн хувьд биднээс хоцрогдолтой яваа эдийн засаг тэлэх хандлагатай улс орнуудад энэ үйл ажиллагаагаа нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. Жишээ нь Узбекистан улс нээлттэй бодлого явуулж эхэлсэн бөгөөд тэнд ОХУ, Солонгосын технологийн компаниуд шийдэл нийлүүлж эхэлж байна. Бидний хувьд ч энэ зах зээл тун боломжийн гэж харагдаж байна.

Хувьцаа эзэмшигч Ж. Энхтунгалаг:

Бизнес төлөвлөгөөнөөс харахад крипто арилжаанд оролцоно гэсэн үг мөн үү? Мөн өөр компанийн хувьцаа хямдарсан байгаа дээр худалдаж авч болохгүй юу? Мөнгөө түгжиж байхаар.

Компанийн захирал О.Амартүвшин:

Таны тавьсан санал тун зөв санал байна, санхүүгийн бүтээгдэхүүнүүд хямдарсан үед нь худалдаж авах хөрөнгө оруулах гэдэг тал дээр бид санал нэг байна. Бид энэ талаар судалж үзээд хөрөнгийн бирж, санхүүгийн зохйцуулах хорооноос ямар нэгэн хориглосон хууль байхгүй бол бид энэ талаар илүү дэлгэрнгүй судалж үзэе.

Дараагийн асуудал буюу Компанийн өөрчлөн байгуулах, хэлбэр өөрчлөх эсэх тухай, асуудал руу ороё.

Бид урьд нь хэлэлцэж үзээд компанийг дампууруулах уу, ХХК болгох уу гээд олон талаас нь авч үзсэн. Хамгийн боломжтой шийдвэр нь ямар ч байсан үл хөдлөхийн зах зээлээс гарах ёстой юм байна гэсэн шийдвэр байсан. Одоогоор бид үл хөдлөх хөрөнгөө зарж борлуулах арга хэмжээг авч байна. Энэ үйл ажиллагаа нь нилээн удаан үргэлжлэх байх. Мөн компанийн үйл ажиллагааны алдагдал буурсан, өрийн дарамт арилсан тул одоогоор энэ хэвээр үргэлжлэх саналтай байна. Энэ талаар асуух асуулт байна уу?

Хурлын дарга Г.Оюунболд:

Өөрчлөн байгуулах асуудлаар асуух асуулт байна уу? Хэрэв байхгүй бол Өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх, шаардах эрх хэрэгжүүлэх тухай хэлэлцэё.

Компанийн захирал О.Амартүвшин:

Үнэт цаасны зах зээлтэй холбоотой Евразиа Капитал Холдинг ҮЦК ХК – үйл ажиллагаа идвэхгүй байна. Тийм учир компани татан буугдахаар төлөвлөж байгаа ба үүнтэй

UNITE
AND

холбоотой компани өөрсдийн компанийн хувьцааг эргүүлэн худалдан аваачээ гэсэн санал нэлээн дээр тавьсан. Энэ талаар Г.Оюунболд захирал өөрөө дэлгэрэнгүй ярих байх.

Хурлын дарга Г.Оюунболд

Тийм. Бид хуулийн дагуу хүсэлтээ тавьсан. Би өөрөө компанид ТУЗ-ын дарга хийж байгаа учир харилцагчаа бодон Би Ди Сек компани, болон бусад хувьцаа эзэмшигчдын хувьцааг эхлээд худалдан авах саналыг дэмжсэн. Манай Евразиа Капитал Холдинг компани татан буугдахаар төлөвлөж байгаа ба татан буугдахад бүх өр төлбөр, тооцоо, авлага, өглөг дуусаж байж улсын бүртгэлээс хасагдана. Тийм учраас манай дээр байгаа хувьцааг бид өөрсдөө зарах, эсвэл компанид эргүүлэн худалдан аваачээ гэдэг санал тавихгүй бол бид татан буугдсаны дараа буюу тамга тэмдэггүй болсон тохиолдолд хэн ч энэ компанийг төлөөлөх эрхгүй болох юм. Тиймээс бид компанид зах зээлийн дундаж үнээр нь буюу 300 төгрөгөөр зарья гэдэг санал тавьсан. Бидний шалтгаан бол улсын бүртгэлээс хасагдаж байгаа учир бид энэ саналыг тавихаас өөр арга байгүй байгаа юм.

Компанийн захирал О.Амартүвшин:

Манай зүгээс бид Оюунболд захиралд бид эхний арилжаагаа дуусгаад Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар оруулж шийдье гэдэг санал тавьсан. Энэ талаар асуух асуулт байна уу?

Хурлын дарга Г.Оюунболд

Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөж байгаа учир компани заавал компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шинчилсэн найруулгыг батлах хэрэгтэй байгаа. Өөрчлөлт оруулаад 14 хоног дотор улсын бүртгэлд бүртгүүлэхгүй бол тэр шийдвэр өөрөө хүчингүй болно. Тийм учир танай компани урьдны хурлаар шийдсэн боловч одоо хүчингүйд тооцсон байгаа. Тэгэхээр энэ хурлаар энэ шийдвэрийг оруулж улсын бүртгэлд дахин өгч байж энэ хүчин төгөлдөр болж дүрэмд өөрчлөлт орох ёстой. Мөн санхүүгийн зохицуулах хороонд эхэлж энийг өгөх ёстой.

Дараагийн асуудал бол Ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсэн тухай ТУЗ-ын шийдвэрийг байгаа юм байна.

Компанийн захирал О.Амартүвшин:

Компанийн алдагдал буурсан хэдий ч ноогдол ашиг хувиарилах хэмжээнд хүрээгүй учир ногдол ашиг хувиарлахгүй гэсэн шийдвэр гаргасан.

Дараагийн асуудал бол их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухайн юм. Энэ тал дээр манайх үл хөдлөх хөрөнгө зарж байгаа. Саяхан Реженси – барилгын 3-р давхарт байрлах байрыг зах зээлийн үнээс буулгаж зарсан. Учир нь хамгийн дээд үнийг санал болгосон компанид энэ байсан юм. Мөн 1 давхарт зах зээлийн үнээс доогуур худалдаж авах хэд хэдэн санал ирсэн. Дансны үнээс бага байгаа учир бидэнд борлуулахд бэрхшээлтэй байна мөн манай менежментийн баг шууд их алдагдал хүлээх ашиггүй саналууд дээр татгалзаж байгаа байгаа. Мөн 1 давхарын мексикан болон суп бар рестораны гэрчилгээ гарахдаа дундын нойлын өрөөг оруулж гаргасан байдаг юм байна.

Гэвч түрээслэгч тал хэмжилт хийхэд хэмжилт нь гэрчилгээ нь дээрээсээ өөрөөс гарсан. Худалдаж авах тал ирээд бид дундын нойл орсон хэсгийг худалдаж авахгүй гэрчилгээ нь дээрээ буруу гаргасан гэсэн асуудлыг тавьж байгаа. Тэгээд бид хасаад зарахаар бид өөрсдөө м2 –ын үнэлгээгээ бууруулж зарсан гэж харагдах гээд байгаа талтай. Мөн 2 давхрын байрыг худалдаж авах санал ирсэн. Мөн зах зээлийн хашнаас буулгаж авахаар санал байна. Мөн 2 давхрын фитнесс заалыг зарах дээр хэлцэл хийгдэж нөгөө талаас мөнгөө цувуулж өгнө гэсэн санал тавьсан байгаа. Гэрээгээ энэ долоо хоногт хийнэ гэж тохиролцоог хийсэн байгаа. Энэ гэрээнүүд нь их хэмжээний хэлцэл болж байгаа ба энэ мөнгөөрөө Евразиа Компанийн хувьцааг худалдаж авна гэж үзвэл энэ нь сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж харагдаж байна.

Хурлын дарга Г.Оюунболд

Харин тийм. Би энэ компанийн ТУЗ-ын дарга учир энэ нь сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж харагдаад байгаа. Тийм болохоор би энийг хурлаар шийдвэрлэх сонирхолтой байна. Мөн Фронтнер Лэнд Групп ХК – нь манай Евразиа Капитал Холдинг ҮЦК ХК тай зөвлөх үйлчилгээны гэрээг ТУЗ – тай эхэлж ярилцаад ТУЗ – аас зөвшөөрөл авч хийсэн байгаа. Энэ хурлаар мөн энэ асуудлыг оруулж ирж байгаа нь би өөрөө ТУЗ – ын дарга байж давуу эрх ашиглан энэ гэрээг хийсэн гэж харагдаж байгаа учраас энэ хурлаар үүнийг нээлттэйгээр шийдүүлэх хүсэлтэй байгаа юм.

Компанийн захирал О.Амартүвшин:

Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээг хэлэлцэх, сунгах тал дээр би нэг юм хэлэх гэсэн юм. Төслийн санаачлагч Ганбат – энэ жилээс төслийг эхэлнэ гэж байсан харамсалтай нь цар тахал гарсан байгаа учир хойшлогдох болов уу. Хэрэв төсөл эхлэх юм бол нөгөө талаас (Ганбат) манай газар, тоног төхөөрөмжийг худалдаж авна гэсэн гэрээг хийсэн байгаа. Тиймээс манай энэ гэрээг сунгаж явах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Хурлын дарга Г.Оюунболд

Бидны зүгээс энэ гэрээг сунгах хэрэггүй гэж үзэж байгаа. Би шүүхэд өгнө гэсэн санал байгаа. Энэ нь бараг 10 жил болж байна шүү дээ.

Компанийн захирал О.Амартүвшин:

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд бид хагас тэрбум гарну төгрөг зарцуулсан байна. Бид энэ төлбөрийг гэрээ нь дээр эргүүлэн авах зүйл бол байгаа. Энэ хийх гэж байгаа төслийг судлаад үзэхээр нааштай явж байгаа юм байна лэй. Удахгүй эхлэх байх.

Хуралд оролцогчид:

Энэ яг юуны төсөл юм бэ?

Компанийн захирал О.Амартүвшин:

Энэ төсөл нь усан цахилгаан станцын төсөл байгаа юм. Сонгино хайрхан дүүрэг, Богд уулын энгэрт усан сан байгуулж төв цэвэрлэх байгууламжын усыг цэвэршүүлэн шөнийн

...шаардлагатай гэж үзэж байна. Мөн
энэ гэрээний хэрэгжилттэй холбоотой эрх зүйлийн байдал

хямд тарифаар усаа уул өөд татаад, өдрийн цагаар буцааж буулган цахилгаан гарган авах төсөл байгаа юм.

Хурлын дарга Г.Оюунболд

Фронттиер Лэнд Групп ХК нь анх Туул Сангийн Усны Нөөц гэдэг нэртэй байж байгаад компани хувьцаат компани болсон юм. Энэ компанийг үүсгэн байгуулагч Ганбат нь энэ олон нийтээс босгосон мөнгөө шамшигдуулсан. Ганбат компаниас гарсан боловч энэ мөнгөө эргүүлэн төлөх учир бид энэ гэрээг хийгээд одоог хүртэл явж байгаа.

Энэ гэрээг энэ хэвээр сунгалгүйгээр мэргэжлийн хуулийн компаниас зөвлөгөө авч гэрээний төслийг шинэчлэн боловсруулж байгуулах шаардлагатай гэж үзэж байна. Мөн энэ гэрээний хэрэгжилттэй холбоотой эрх зүйлийг компанийн төлөөлөн удирдах зөвлөлд өгөх хүсэлтэй байна.

Хуралд оролцогчид:

Энэ газар нь манай газар гэсэн үгүү?

Хурлын дарга Г.Оюунболд

Тийм. Өөр компанийн нэр дээр байхад нь бид шилжүүлж авсан. Бид энэ гэрээг сунгах тал дээр хуулийн компаниас зөвлөгөө авсан дээр байх. Та хэд юу гэж бодож байна да?

Компанийн захирал О.Амартүвшин:

Өөр асуух зүйл байхгүй бол бусад гэсэн хэсэг рүү ороё. Би Ди Сек компанийн захирал Даянбилгүүн ТУЗ –аас өөрийн хүсэлтээр гарах болсон. Тиймээс бид шинээр ТУЗ – д хүн сонгох болж байна. ТУЗ –ын гишүүнээр хэн ч нэрээ дэвшүүлж болно.

Хурлын дарга Г.Оюунболд

Хөрөнгө оруулалтын сангийн зүгээс гүйцэтгэх захирлыг сонгох хүсэлт ирүүлсэн. Компанийн үйл ажиллагааг илүү сайн мэдэж байгаа болохоор бидний зүгээс бас ижил саналтай байна.

Компанийн захирал О.Амартүвшин:

Бусад гэсэн зүйл дээр бид мөн ТУЗ –ын цалин урамшууллыг оруулж өгсөн байгаа. ТУЗ – нийт 9 хүнтэй нэг нарийн бичгийн даргатай байгаа. Нэг хүний цалин гэж 400 мянган төгрөг байгаа. ТУЗ – ын гишүүд 2 жилээр сонгогддог учир өнгөрсөн жил бид ТУЗ – аа баталсан байгаа. Тиймээс дахиж батлах хэрэггүй гэж үзэж байна.

Хуралд оролцогчид:

Компани нийт хэдэн хүнтэй ажиллаж байгаа вэ?

Компанийн захирал О.Амартүвшин:

Компани 4 хүнтэй ажиллаж байгаа ба гэрээгээр 1 хүн ажиллаж байна. Нэг хүн авах хэрэг байгаа боловч бид зардлаа хэмнэх үүднээс авахгүй байгаа.

Хэрэв дууссан бол санал хураалтаа явуулах уу?

Хуралд оролцогчид:

Зөвшөөрч байна.

Тооллогын комиссийн дарга:

Санал хураалт явагдаж дууссан байна.

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах – 100 хувиар батлагдсан байна.
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах. – 76 хувиар батлагдсан байна.
3. Компанийн өөрчлөн байгуулах, хэлбэр өөрчлөх эсэх тухай, компанийн цаашдын үйл ажиллагааг хэрхэх эсэх тухай – 76 хувиар батлагдсан байна.
4. Өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх, шаардах эрх хэрэгжүүлэх тухай хэлэлцэх – 100 хувиар батлагдсан байна.
5. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилсэн найруулгыг батлах – 76 хувиар батлагдсан байна.
6. Ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсэн тухай ТУЗ-ын шийдвэрийг танилцуулах – 100 хувиар батлагдсан байна.
7. Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл батлах - 76 хувиар батлагдсан байна.
8. Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээг хэлэлцэх, сунгах – 76 хувиар батлагдсан байна.
9. Бусад – дээр хэлэлцэгдсэн /ТУЗ-ын ердийн гишүүн сонгох/асуудлыг 100 хувиар баталсан байна.

Ингээд 9 асуудал бүгд батлагдсан байна.

Хурлын дарга Г.Оюунболд хурлыг хаав.

Хурал: 16 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн

Хянасан:

Хурлын дарга: Г.Оюунболд

У.Анар

Г.Оюунболд